

Монгол Улс 2021, 2022 онд ихээхэн хэмжээний гадаад бондыг эргэн төлөх тул төсвийн зарлага, алдагдлын хэмжээг 2020 онд эрс бууруулах шаардлагатай байна.

2020 ОНЫ ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ

ТӨСВИЙН АЛДАГДАЛ

-2.1 их наяд төгрөг

Нэгдсэн төсвийн алдагдал өсөж 2.1 их наяд төгрөг болно.

НИЙТ ЗАРЛАГЫН ӨСӨЛТ

↑ 1.6 их наяд төгрөг

Төсвийн нийт зарлага өмнөх оноос 1.6 их наяд төгрөгөөр өснө.

ХӨРӨНГИЙН ЗАРЛАГЫН ӨСӨЛТ

↑ 250 тэрбум төгрөг

Хөрөнгийн зарлага өмнөх оноос 250 тэрбум төгрөгөөр өснө.

ТӨСВИЙН АЛДАГДАЛ



Засгийн газраас нэгдсэн төсвийн алдагдлыг 2020 онд өндөр хэвээр буюу өмнөх оны түвшнээс нэмэгдэж 2.1 их наяд төгрөг байхаар төлөвлөжээ. Харин 2021 оноос эхлэн төсвийн алдагдлыг бууруулж 1.3 их наяд төгрөг, 2022 онд 729 тэрбум төгрөг болохоор байна.

ГАДААД ҮНЭТ ЦААСНЫ ЭРГЭН ТӨЛӨЛТ


1.5 тэрбум ам.доллар

Засгийн газар 2021-2022 онд нийт 1.5 тэрбум ам.долларын гадаад үнэт цаасыг эргэн төлнө.

Засгийн газар 2021-2024 онд нийт 2.9 тэрбум ам.долларын гадаад үнэт цаасыг эргэн төлнө:

- 2021 онд 500 сая ам.долларын Мазаалай бонд
- 2022 онд 1 тэрбум ам.долларын Чингис бонд
- 2023 онд 600 сая ам.долларын Хуралдай бонд
- 2024 онд 800 сая ам.долларын Гэрэгэ бонд

ТӨСВИЙН НИЙТ ЗАРЛАГЫН ӨСӨЛТ



Төсвийн нийт зарлага 2020 онд өмнөх оноос их хэмжээгээр буюу 1.6 их наяд төгрөгөөр өсөхөөр байна. Харин 2021 онд төсвийн зарлага өмнөх оноос зөвхөн 136 тэрбум төгрөгөөр, 2022 онд өмнөх оноос 304 тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр байна.

ХӨРӨНГИЙН ЗАРЛАГА



3.4 их наяд төгрөг

2020 онд хөрөнгийн зарлага өмнөх оноос 250 тэрбум төгрөгөөр өсөж 3.4 их наяд төгрөг байхаар төлөвлөгджээ. Харин хөрөнгийн зарлага 2021 оноос буурч 2.9 их наяд төгрөг байхаар байна.